

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/01

Арвайхээр сум

Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын тусгай зөвшөөрөл сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2,19.3,19.14, 19.15, 19.18, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 14,15, Эрүүл мэндийн сайдын 2023 ны а/383 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын ажиллах журам”- ын 4:5, 5.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой ажлыг гүйцэтгэх ажлын албаны ирүүлсэн санал, дүгнэлт, Эрүүл мэнд эм хангамжийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох комиссын 2024 оны 01 дугаар сарын 02 -ны өдрийн шийдвэрийг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгах нэр бүхий аж ахуйн нэгжийн нэрийг нэгдүгээр, өөрчлөлт оруулах нэр бүхий аж ахуйн нэгжийн нэрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга (Я. Жаргалд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

622301001

Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны
01 дүгээр сарын 13 ны өдрийн 01 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ НЭР БҮХИЙ АЖ АХУЙН
НЭГЖИЙН НЭР

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Сунгах хугацаа	Хүчинтэй байх хугацаа/огноо
1	"Цуврайн гол" ЗГБХНөхөрлөл(РД: 2129817)	Ахуйн хортон шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх, ариутгал	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5-р баг	5 жил	2028 оны 11-р сарын 13-ны өдөр хүртэл
2	Амар-Оптик "ХХК, "Мэлмий гийх" нүдний эмнэлэг (РД:3561852)	Нүдний тусламж, үйлчилгээ	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13 дугаар баг, 101 дүгээр байр, 3 тоот	5 жил	2028 оны 07 дугаар сарын 22 ны өдөр хүртэл
3	Сувд хувийн хэвшлийн эмийн сан(РД:3557022)	Нийтийн үйлчилгээтэй 2-р зэрэглэлийн эмийн сан	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5-р баг	5 жил	2028 оны 12 дугаар сарын 25 ны өдөр хүртэл

Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны
01 дүгээр сарын 02 ны өдрийн 101 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Нэмэлт өөрчлөлтийн агуулга
1	Амар-Оптик "ХХК, "Мэлмий гийх" нүдний эмнэлэг (РД:3561852)	Нүдний тусламж, үйлчилгээ	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13 дугаар баг, 101 дүгээр байр, 3 тоот	Өвөрхангай аймаг. Арвайхээр сум. 5-р баг хаягнаас Арвайхээр сумын 13 дугаар багийн 101 дүгээр байрны 3 тоотод шилжсэн тул хаягийн өөрчлөлт хийх

---oOo---